



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/160

Хэрлэн сум

### Төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны хүрээнд төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 340 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хорин гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Хэнтий аймгийн Засаг даргын хооронд төрийн зарим чиг үүргийг 2024 оны орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 2.18 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлыг төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны хүрээнд төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхэд 30,000,000 (Гучин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ